



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 1151

Улаанбаатар хот

**Хамран сургах тойргийн төслийг боловсруулах
ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын ерөнхий хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 2026-2027 оны хичээлийн жилийн хамран сургах тойргийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ахлагч:	Дүүргийн Боловсролын хэлтсийн дарга
Гишүүд:	Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга Дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Дүүргийн Статистикийн хэлтсийн дарга Дүүргийн 1-24 дүгээр хороодын Засаг дарга нар Төрийн өмчийн Ерөнхий боловсролын сургуулийн захирлууд Төрийн өмчийн Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч нар
Нарийн бичгийн дарга:	Дүүргийн Боловсролын хэлтсийн Сургалт хариуцсан мэргэжилтэн (Бага боловсрол) Дүүргийн Боловсролын хэлтсийн Сургуулийн өмнөх боловсролын сургалтын арга зүй, багшийн мэргэжлийн хөгжил, гүйцэтгэлийн үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

2. Ажлын хэсгийг нэгдсэн удирдлагаар хангаж, шинээр ашиглалтад орох орон сууцны хороолол, хүн амын тоотой уялдуулан иргэдийн саналыг тусгаж, хамран сургах тойргийн төслийг боловсруулж танилцуулахыг Ажлын хэсэг (Ц.Цолмонбаатар)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (Н.Бямбагэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.МАНДУУЛ